GOBI
MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХК-ИЙН 2021 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| | |
|---|---|
| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/* | 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | *Компанийн нэр:* "Говь" ХК<br>*УБГД:* 9010001061<br>*Үнэт цаасны код:* MN00GOV03548<br>*Утасны дугаар:* (+976) 7013-9977 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын Хөрөнгийн Бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Ямааны ноолуур, тэмээний ноосонд боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх. |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 780,112,500 |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн:<br>М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/<br>Хянасан:<br>Ч.Солонго /Тэргүүн дэд захирал/ |

| | | |
|---|---|---|
| *1.* | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | 3-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт-1/ |
| | *Орлогын тайлан* | |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | |
| | | |

<table>
<tr><td>2.</td><td colspan="2">Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Эрсдэл, аудитын хорооны шийдвэрийг хамт хавсаргав. /Хавсралт-2/</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="2">Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</td></tr>
<tr><td>3.1.</td><td>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td><td rowspan="2"><table>
<tr><th>Үзүүлэлт (өссөн)</th><th>2020.9 Гүйцэтгэл</th><th>2021.9 Гүйцэтгэл</th></tr>
<tr><td>Бохир ашгийн маржин > 40%</td><td>39%</td><td>43%</td></tr>
<tr><td>Цэвэр ашгийн маржин > 10%</td><td>-55%</td><td>-35%</td></tr>
<tr><td>Эргэлтийн харьцаа > 1</td><td>1.3</td><td>0.8</td></tr>
<tr><td>Бараа материалын эргэц < 365</td><td>940.3</td><td>915.4</td></tr>
<tr><td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td><td>199.50</td><td>323.76</td></tr>
</table></td></tr>
<tr><td>3.2.</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</td></tr>
<tr><td>3.3.</td><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</td><td>• Монгол улсын хувьд хэдийгээр хил нээлттэй байгаа боловч Ковид-19 вирусын тархалт ихтэй байгаа тул гадны жуулчид Монгол улсыг зорьж ирэх нь багассан нь дотоодын борлуулалтад сөргөөр нөлөөлж байна. Иймд дотоодын худалдан авагчдынхаа халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, хүмүүсийн бөөгнөрлийг багасгах, мөн борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор "www.gobi.mn" онлайн сайтыг ашиглалтад оруулснаар гэрээсээ худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>• Гадаад борлуулалтаа нэмэгдүүлэх, Говь брэндийн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгын хүрээнд олон улсад онлайн худалдааны сувгуудаа эрчимтэй нэмэгдүүлэн, маркетинг идэвхжүүлэлтийн ажлууд дээр төвлөрч ажилласан.<br>• Цар тахлын нөхцөл байдалд үйлдвэрлэлээ тасралтгүй бөгөөд чанартай явуулахын тулд компанийн хэмжээнд халдвар ихэссэн тохиолдолд нийт ажилтнуудыг 2 ээлжээр ажиллуулах, гэрээс ажиллуулах зэргээр үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган зохион байгуулалт хийн ажилласан. Мөн нийт ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахын тулд оффис, үйлдвэрийн халдваргүйжүүлэлт, дархлаа дэмжих хоол хүнс, витаминаар тогтмол хангаж байна.</td></tr>
<tr><td>3.4.</td><td>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</td><td>Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *4.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* |
| | *(мян.төг)* (see table below) |
| *5.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл* |
| | Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно. |
| *6.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |

*(мян.төг)*

| ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ | 2021.09.30 |
|---|---:|
| Холбоотой талд өгсөн санхүүжилт | 6,838,200 |
| Холбоотой талаас авсан санхүүжилт | 23,933,456 |
| Холбоотой талтай хийсэн борлуулалт | 86,233 |
| Холбоотой талаас авсан худалдан авалт | 640,660 |
| Хүүгийн орлого | - |
| Хүүгийн зардал | 1,718,234 |
| Түрээсийн орлого | 139,659 |
| Түрээсийн зардал | 451,327 |

"Говь" ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангилал, ТОП 20 индекст багтдаг нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.
Манай компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм. Бид үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журмыг баримтлан ажилладаг.

2021.09.30-ний байдлаар нийт 19,662 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Таван Богд Трейд ХХК (392,745,306 ширхэг хувьцаатай буюу 50.34% эзэмшдэг) болон Хиде Интер ХХК (265,238,300 ширхэг хувьцаатай буюу 34.00% эзэмшдэг) юм.

2020.04.24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүд (5 хараат бус, 4 ердийн гишүүн)-ийг 3 жилийн хугацаатайгаар томилсон бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн дэргэд 3 хороо (Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо) үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал хоёр сар тутам, Эрсдэл аудитын хороо улирал тутам, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороо жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн гишүүд өөрийн эрх үүргийн хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

ТУЗ-ийн зүгээс жил бүр компанийн засаглалын үнэлгээг хийж МХБ болон өөрийн веб хуудсаар дамжуулан тайлагнадаг бөгөөд ТУЗ-ийн өөрийн үнэлгээг дотооддоо тогтмол хийн үйл ажиллагаагаа дүгнэн сайжруулдаг.

"Говь" ХК нь сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр хангаж, санал хүсэлт асуулт бүрд дор бүр нь хариу өгч ажилладаг.

| | |
|---|---|
| 7. | *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл.* |
| | 2021.07.01-2021.09.30-ны байдлаар Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг 2021.07.08-ний өдөр, ТУЗ-ийн ээлжит хурлыг 2021.08.26-ний өдөр, Эрсдэл аудитын хорооны ээлжит хурлыг 2021.09.28-ний өдөр тус тус зохион байгуулан ажилласан. Тус хугацаанд нийт 11 тогтоолыг (үйл ажиллагаатай холбоотой 9 тогтоол, санхүүжилттэй холбоотой 2 тогтоол) баталж, 5 ээлжит бус хурлыг зарлан хуралдуулсан.<br><br>Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд info.gobi.mn компанийн веб хуудсыг шинэчлэн, агуулга мэдээллийг илүү дэлгэрэнгүй болгон хувьцаа эзэмшигчдээ мэдээллээр ханган ажиллаж байна.<br><br>Компанийн хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төлөвлөгөөт хугацаанд зохицуулагч байгууллагууд руу илгээн тайлагнасан бөгөөд 2021.08.23-ны өдөр компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайланг МХБ-тэй хамтран олон нийтэд танилцуулан тайлагнасан. |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: Ц.Баатарсайхан<br><br>Албан тушаал: “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ...............................................<br><br>(Тамга/тэмдэг) | Овог, нэр: .........................................................................<br><br>Албан тушаал : “...” Аудитын компанийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ........................................................<br><br>(Тамга/тэмдэг) |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ........................................................

GOBI
MONGOLIAN CASHMERE

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

# **НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

*2021 оны 09 сарын 30*

**GOBI** MONGOLIAN CASHMERE

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*(мян.төг)*

| | *2021.09.30* | *2020.12.31* |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| ***Эргэлтийн хөрөнгө*** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 3,740,110 | 12,798,745 |
| Дансны ба бусад авлага | 14,762,149 | 5,996,260 |
| Урьдчилгаа төлбөр | 4,102,526 | 3,000,896 |
| Бараа материал | 169,105,116 | 193,207,689 |
| Орлогын албан татварын авлага | 201,313 | 265,286 |
| Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө | 464,887 | 646,063 |
| | **192,376,102** | **215,914,938** |
| ***Эргэлтийн бус хөрөнгө*** | | |
| Үндсэн хөрөнгө | 148,226,264 | 156,243,324 |
| Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө | 1,391,787 | 2,631,104 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 4,921,004 | 4,073,481 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгүүд | 1,086,759 | 950,981 |
| | **155,625,814** | **163,898,890** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **348,001,916** | **379,813,828** |
| | | |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| ***Богино хугацаат өр төлбөр*** | | |
| Дансны ба бусад өглөг | 24,681,773 | 21,934,076 |
| Гэрээний өр төлбөр | 2,381,620 | 1,541,384 |
| Буцаах эрхтэй барааны өр төлбөр | 715,211 | 1,010,634 |
| Орлогын албан татварын өглөг | 79,885 | 46,241 |
| Богино хугацаат түрээсийн өглөг | 779,965 | 1,001,198 |
| Богино хугацаат банкны зээл | 209,913,962 | 267,714,096 |
| | **238,552,416** | **293,247,630** |
| ***Урт хугацаат өр төлбөр*** | | |
| Урт хугацаат түрээсийн өглөг | 875,170 | 1,900,851 |
| Урт хугацаат банкны зээл | 42,900,000 | 4,458,498 |
| Урт хугацаат өглөг | 26,343,501 | 14,955,172 |
| | **70,118,671** | **21,314,521** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **308,671,087** | **314,562,151** |
| ***Эзэмшигчдийн өмч*** | | |
| Хувьцаат капитал | 780,113 | 780,113 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 48,870,401 | 48,974,836 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | (289,011) | (1,362,032) |
| Хуримтлагдсан ашиг | (10,030,673) | 16,858,760 |
| | **39,330,830** | **65,251,677** |
| **Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **348,001,916** | **379,813,828** |

GOBI
MONGOLIAN CASHMERE

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
## НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

*(мян.төг)*

| | *2021.09.30* | *2020.12.31* |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | 77,730,188 | 117,092,505 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (44,512,920) | (71,536,490) |
| **Нийт ашиг** | **33,217,268** | **45,556,015** |
| Санхүүгийн ба бусад орлого | 534,689 | 2,615,647 |
| Бусад олз ба (гарз) | 1,484,210 | (8,480,653) |
| Хүүгийн зардал | (19,022,254) | (29,542,260) |
| Борлуулалт ба маркетингийн зардал | (33,132,213) | (44,384,939) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (10,755,827) | (13,076,638) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт | - | (170,306) |
| **Татварын өмнөх ашиг** | **(27,674,128)** | **(47,483,133)** |
| Орлогын татварын зардал | 784,695 | 1,327,791 |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | **(26,889,433)** | **(46,155,342)** |
| **Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:** | | |
| Гадаад дахь охин компанийн цэвэр хөрөнгийн хөрвүүлэлтийн зөрүү | 1,073,021 | (1,083,503) |
| **Бусад дэлгэрэнгүй алдагдал** | **1,073,021** | **(1,083,503)** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | **(25,816,412)** | **(47,238,844)** |

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
# НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(мян.төг)*

| | Хувьцаат капитал | Дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **780,113** | **15,647,697** | **(278,530)** | **63,014,101** | **79,163,382** |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | (46,155,342) | **(46,155,342)** |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | 33,327,139 | (1,083,503) | | **32,243,637** |
| Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | | **33,327,139** | **(1,083,503)** | **(46,155,342)** | **(13,911,705)** |
| Зарласан ногдол ашиг | | | | | |
| **2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **780,113** | **48,974,836** | **(1,362,032)** | **16,858,760** | **65,251,677** |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | (26,889,433) | **(26,889,433)** |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | (104,436) | 1,073,021 | | **968,585** |
| Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | (104,436) | 1,073,021 | (26,889,433) | **(25,920,848)** |
| Зарласан ногдол ашиг | | | | | |
| **2021 оны 09 сарын 30-ний үлдэгдэл** | **780,113** | **48,870,401** | **(289,012)** | **(10,030,673)** | **39,330,830** |

GOBI
MONGOLIAN CASHMERE

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
## НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(мян.төг)*

| | *2021.09.30* | *2020.12.31* |
|---|---|---|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (6,726,899) | (30,565,123) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (4,253,056) | (6,250,007) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 3,143,644 | 38,585,512 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (7,836,311) | 1,770,382 |
| Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл | (1,222,324) | 386,619 |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **12,798,745** | **10,641,744** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,740,110** | **12,798,745** |

“Говь” ХК 2021 оны 3-р улирал тайлангийн Хавсралт-2

MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 22 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

*2021 оны 3-р улирлын санхүүгийн тайланг дүгнэх тухай*

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Говь” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК-ийн 2021 оны 3-р улирлын санхүүгийн тайлан үнэн зөв болохыг үүгээр баталсугай.
2. Улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Гишүүд Д.ХУЛАН

А.ЖАРГАЛМАА

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТ 2998 ₮ 2076351